МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 29 өдөр Дугаар А/131 Морөн сум

"Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр"-ийн
үйл ажиллагааны жагсаалт, төсөвт өртөг
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, 41.2.6, 65.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ажлын жагсаалт, төсөвт өртгийг хавсралтаар батлсугай.

2. Батлагдсан арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсорогдог)-т даалгасугай.

3. Төлөвлөгдсөн бараа, ажил, үйлчилгээг үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжилтийг тухай бүр тооцож, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа)-т, Санхүү төрийн сангийн хэлтэс (Г.Базар)-т тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2023

671 010000

Аймгийн Засаг даргын 2023 оны
...03... сарын ...29...-ны өдрийн ...А/131...
тоот захирамжийн хавсралт

ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ЖАГСААЛТ, ТӨСӨВТ ӨРТӨГ

№	Зардлын утга	Нийт үнэ
1	Багц-1 Жаргалант сумын Цэцүүх багт баригдах Багийн төвийн барилга	255,650,000 (хоёр зуун тавин таван сая зургаан зуун тавин мянга)
2	Багц-2 Жаргалант сумын Цагаанбургас багт баригдах Багийн төвийн барилга	255,650,000 (хоёр зуун тавин таван сая зургаан зуун тавин мянга)
	Нийт:	511,300,000 (таван зуун арван нэгэн сая гурван зуун мянга)

_____o0o_____